**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 18 өдөр Дугаар А/51 Улаанбаатар хот

Шүүх шинжилгээний байгууллагын
алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл,
нийгмийн баталгааг хангах хөтөлбөр,
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 61 дүгээр зүйл, Шүүх шинжилгээний тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.2, 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.10 дахь заалт, 71 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгуулах арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, хангамжийн газрын дарга (цагдаагийн хурандаа Х.Саранчимэг)-д даалгасугай.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, төв, хэлтсийн дарга нарт, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Дэд дарга (цагдаагийн хурандаа Э.Халиунбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Хөтөлбөр батлах тухай” 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/33 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ж.БУЯНБАТ

Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын
2025 оны 03 дугаар сарын 18 – ны өдрийн
А/51 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧ, АЖИЛТНЫ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР /2025-2028 он/

## Нэг. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

1.1.Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 61, 62 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Ахмад настны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

## Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1.Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагч, ажилтны ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах замаар тэдний ажлын бүтээмж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлж, ахмад ажилтнуудад тусламж, дэмжлэг үзүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

## Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1.Хөтөлбөрийг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

3.1.1.Алба хаагч, ажилтны ажиллах орчин, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах;

3.1.2.Алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах;

3.1.3.Алба хаагч, ажилтны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх;

3.1.4.Ахмад ажилтанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

## Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1.Хууль дээдлэх;

4.1.2.Тэгш хүртээмжтэй байх;

4.1.3.Ил тод байдлыг хангах;

4.1.4.Бодитой, үр дүнтэй байх;

4.1.5.Нөөц бололцоог бүрэн дайчлах;

## Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл, үйл ажиллагаа

5.1.Алба хаагч, ажилтны ажиллах орчин, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1.1.Ажлын байрны эрүүл ахуйн стандартыг мөрдүүлж, алба хаагч, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;

5.1.2.Бүсийн шүүх шинжилгээний төв болон аймгийн шүүх шинжилгээний хэлтсийг лабораторийн зориулалттай байртай болгох;

5.1.3.Алба хаагчдыг дэвшилтэт тоног төхөөрөмж, компьютер, техник хэрэгслээр хангах;

5.2.Алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.2.1.Гүйцэтгэж буй ажил үүргийн онцлогтой уялдуулан алба хаагчдын цалингийн зэрэглэлийг нэмэгдүүлэх саналыг эрх бүхий байгууллагад уламжлах;

5.2.2.Алба хаагч, ажилтны амьдрах орчин нөхцөлийн судалгааг жил бүр шинэчлэн гаргаж, удирдлагад танилцуулж, "Ипотекийн зээлийн журам"-д заасан болзол, шалгуур хангасан алба хаагчдын зээлийн хүсэлтийг шийдвэрлүүлэх, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, орон нутгаас хэрэгжүүлж буй орон сууцны төсөл, хөтөлбөр болон хөнгөлөлттэй үнээр орон сууцанд хамруулах, орон сууцны урьдчилгаа, орчин, ахуй нөхцөлөө дээшлүүлэхэд (хашаа, байшин, гэр) нь дэмжлэг, тусламж үзүүлэх;

5.2.3.Алба хаагч, ажилтны хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж үзүүлэх;

5.2.4.Гэрт болон галлагаатай байшинд амьдардаг алба хаагч, ажилтан, ахмад ажилтнуудад түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх;

5.2.5.Алба хаагч, ажилтныг гэнэтийн ослын даатгал (амь нас, эрүүл мэнд)-д жил бүр хамруулах;

5.2.6.Алба хаагч, ажилтан, түүний гэр бүлийн гишүүдийг албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол, гүтгэх болон бусад хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалалтад авах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

5.3.Алба хаагч, ажилтны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.3.1.Эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, алба хаагч, ажилтныг жилд нэгээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэг, нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах;

5.3.2.Алба хаагч, ажилтны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх, эрүүл мэндээ хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

5.3.3.Алба хаагч, ажилтан, тэдний гэр бүл болон ахмад настны эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх "Сэргээн засах сувилал"-ын үйл ажиллагааг жигдрүүлэх;

5.3.4.Ажлын байранд дасгал хөдөлгөөн хийх, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх зорилгоор бялдаржуулах танхимын үйл ажиллагааг сайжруулж, алба хаагч, ажилтнууд хичээллэх боломжийг бүрдүүлэх;

5.3.5.Алба хаагч, ажилтанд сэтгэл зүйн боловсрол олгох зорилгоор сургалт зохион байгуулж, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, алжаал тайлах зориулалт бүхий өрөө тасалгаа бий болгох;

5.4.Ахмад ажилтанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1.Орон сууцны төсөл, хөтөлбөр болон хөнгөлөлттэй үнээр орон сууцанд хамрагдахад, дэмжлэг, тусламж үзүүлэх;

5.4.2.Ахмад ажилтны хүндэтгэн үзэх шалтгаан, нөхцөлийг харгалзан нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж үзүүлэх;

5.4.3.Сар шинийн баяр болон ахмадын баяр, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулах;

5.5.4.Ахмад ажилтны мэргэжлийн ур чадвар, туршлагыг залуу үеийнхэнд өвлүүлэх, ахмадаасаа суралцах, ахмад үеэ хүндэтгэн бахархах, залуу хойч үедээ ажил, амьдралын туршлагаасаа хуваалцах, зөвлөгөө өгөх, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;

## Зургаа.Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1.Хөтөлбөрийн хэрэгжилтэд Аюулгүй байдал, дотоод хяналт, аудитын асуудал хариуцсан нэгж хагас, бүтэн жилд нэг удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Шүүх шинжилгээний төв байгууллагын удирдлагад танилцуулна.

6.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний болон хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

## Долоо.Хөтөлбөрийн санхүүжилт

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1.Улсын төсөв;

7.1.2.Олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төсөл, хөтөлбөр, хандив, буцалтгүй тусламж;

## Найм.Хөтөлбөрийн үр дүн

8.1.Алба хаагч, ажилтны ажиллах орчин нөхцөл сайжирч, хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдана.

8.2.Алба хаагч, ажилтнууд тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл сайжирна.

8.3.Төрийн албаны гүйцэтгэл, үйлчилгээний чанар, алба хаагч, ажилтны сэтгэл ханамж дээшилнэ.

8.4. Алба хаагч, ажилтнууд бие болон сэтгэл зүйн хувьд эрүүл чийрэг, идэвхтэй амьдралын хэв маяг бүрдсэн байна.

8.5.Алба хаагч, ажилтан, тэдний гэр бүлийн гишүүн болон ахмад настнууд нөхөн сэргээх үйлчилгээ авч, “Сэргээн засах сувилал”-ын үйл ажиллагаа жигдэрсэн байна.

8.6.Ахмад ажилтнуудад дэмжлэг, туслалцаа үзүүлж, нийгмийн амьдралын оролцоо, түвшин сайжирна.

_____oOo_____

Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
А/51.. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧ, АЖИЛТНЫ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**
**(2025-2028 он)**

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2021-2024) | Зорилтот Түвшин (2025-2028) | Хариуцах нэгж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үндсэн | Хамтран |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Нэгдүгээр зорилт. Алба хаагч, ажилтны ажиллах орчин, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах | | | | | | | | |
| 1.1 | Ажлын байрны эрүүл ахуйн стандартыг мөрдүүлж, алба хаагч, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах | Жилдээ | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | ЧБХ | Газар, төв, хэлтэс |
| 1.2 | Бүсийн шүүх шинжилгээний төв болон аймгийн шүүх шинжилгээний хэлтсийг өөрийн байртай болгох | Жилдээ | Улсын төсөв, орон нутгийн дэмжлэг | Баригдсан барилгын тоо | 13 | 15 | СХГ, БШШТ, АШШХ | Газар, төв, хэлтэс |
| 1.3 | Алба хаагчдыг дэвшилтэт тоног төхөөрөмж, компьютер, техник хэрэгслээр хангах | Жилдээ | Улсын төсөв хуулиар хориглоогүй эх үүсвэр | Гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | СХГ, НШШГ, БШШТ, АШШХ | Газар, төв, хэлтэс |
| Хоёрдугаар зорилт. Алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах | | | | | | | | |
| 2.1 | Гүйцэтгэж буй ажил үүргийн онцлогтой уялдуулан алба хаагчдын цалингийн зэрэглэлийг нэмэгдүүлэх саналыг эрх бүхий байгууллагад уламжлах | Жилдээ | - | Хүргүүлсэн саналын тоо | 1 | 1 | ЗУГ, СХГ | Газар, төв, хэлтэс |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Алба хаагч, ажилтны амьдрах орчин нөхцөлийн судалгааг жил бүр шинэчлэн . гаргаж, удирдлагад танилцуулж, “Ипотекийн зээлийн журам”-д заасан болзол, шалгуур хангасан алба хаагчдын зээлийн хүсэлтийг шийдвэрлүүлэх, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, орон нутгаас хэрэгжүүлж буй орон сууцны төсөл, хөтөлбөр болон хөнгөлөлттэй үнээр орон сууцанд хамруулах, орон сууцны урьдчилгаа, орчин, ахуй нөхцөлөө дээшлүүлэхэд (хашаа, байшин, гэр) нь дэмжлэг, тусламж үзүүлэх | Жилдээ | Улсын төсөв | Хамрагдсан алба хаагч, ажилтны тоо | 36 | 40 | СХГ, ЗУГ | Газар, төв, хэлтэс |
| | | | | Тэтгэмжийн мөнгөн дүн | | Гүйцэтгэлээр | | |
| 2.3 | Алба хаагч, ажилтны хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж үзүүлэх | Тухай бүр | Улсын төсөв | Тэтгэмж, тусламж олгосон алба хаагч, ажилтны тоо | 71 | 80 | СХГ, ЗУГ | Газар, төв, хэлтэс |
| | | | | Мөнгөн дүн | | Гүйцэтгэлээр | | |
| 2.4 | Гэрт болон галлагаатай байшинд амьдардаг алба хаагч, ажилтан, ахмад ажилтнуудад түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх | Жилдээ | Улсын төсөв | Хамрагдсан хүний тоо | 204 | 220 | СХГ, ЗУГ | Газар, төв, хэлтэс |
| | | | | Мөнгөн дүн | | Гүйцэтгэлээр | | |
| 2.5 | Алба хаагч, ажилтныг гэнэтийн ослын даатгал (амь нас, эрүүл мэнд)-д хамруулах | Жилдээ | Улсын төсөв | Хамрагдсан алба хаагч, ажилтны тоо | 96 | 400 | АБДХАГ, СХГ, БШШТ, АШШХ | Газар, төв, хэлтэс |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | Алба хаагч, ажилтан, түүний гэр бүлийн гишүүдийг албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол, гүтгэх болон бусад хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах | Тухай бүр | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 4 | 4 | АБДХАГ, БШШТ, АШШХ | Газар, төв, хэлтэс |
| Гуравдугаар зорилт. Алба хаагч, ажилтны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх | | | | | | | | |
| 3.1 | Эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, алба хаагч, ажилтныг жилд нэгээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэг, нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах | Жилдээ | Улсын төсөв | Хамрагдсан алба хаагч, ажилтны тоо | 250 | 400 | АБДХАГ, ШАУШГ | Газар, төв, хэлтэс |
| 3.2 | Алба хаагч, ажилтны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх, эрүүл мэндээ хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | Жилдээ | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 4 | 4 | ЭШСХТ | Газар, төв, хэлтэс |
| 3.3 | Алба хаагч, ажилтан, тэдний гэр бүл болон ахмад настны эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх “Сэргээн засах сувилал”-ын үйл ажиллагааг жигдрүүлэх | Жилдээ | Улсын төсөв | Ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Сэргээн засах сувилал, СХГ | Газар, төв, хэлтэс |
| 3.4 | Ажлын байранд дасгал | Жилдээ | - | Зохион | 5 | 5 | ЭШСХТ, СХГ, | Газар, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлгөөн хийх, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, бялдаржуулах танхимыг тохижуулж, алба хаагч, ажилтнууд хичээллэх боломжийг бүрдүүлэх | | | байгуулсан ажил, арга хэмжээний тоо | | | БШШТ, АШШХ | төв, хэлтэс |
| 3.5 | Алба хаагч, ажилтанд сэтгэл зүйн боловсрол олгох зорилгоор сургалт зохион байгуулж, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх | Жилдээ | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 4 | 4 | ЭШСХТ, ХНХ, БШШТ, АШШХ | Газар, төв, хэлтэс |
| | | | | Сэтгэл заслын үйлчилгээ үзүүлсэн алба хаагч, ажилтны тоо | 50 | 100 | | |
| Дөрөвдүгээр зорилт. Ахмад ажилтанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх | | | | | | | | |
| 4.1 | Орон сууцны төсөл, хөтөлбөр болон хөнгөлөлттэй үнээр орон сууцанд хамрагдахад дэмжлэг, тусламж үзүүлэх | Тухай бүр | Улсын төсөв | Хамрагдсан ахмад ажилтны тоо | 1 | 1 | СХГ, ЗУГ, Ахмадын холбоо | Газар, төв, хэлтэс |
| 4.2 | Ахмад ажилтны хүндэтгэн үзэх шалтгаан, нөхцөлийг харгалзан нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж үзүүлэх | Тухай бүр | Ахмадын сан | Тусламж, тэтгэмж олгосон ахмад ажилтны тоо | 47 | 50 | СХГ, ЗУГ, Ахмадын холбоо | Газар, төв, хэлтэс |
| 4.3 | Сар шинийн баяр болон ахмадын баяр, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулах | Тухай бүр | Ахмадын сан | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 4 | СХГ, ЗУГ, Ахмадын холбоо | Газар, төв, хэлтэс |
| 4.4 | Ахмад ажилтны мэргэжлийн ур чадвар, туршлагыг залуу үеийнхэнд өвлүүлэх, ахмадаасаа | Жилдээ | Ахмадын сан | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | Жилд 1 удаа | ЭШСХТ, Ахмадын холбоо | Газар, төв, хэлтэс |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суралцах, ахмад үеэ хүндэтгэн бахархах, залуу хойч үедээ ажил, амьдралын туршлагаасаа хуваалцах, зөвлөгөө өгөх, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | | | | | | | |

_____oOo_____